

ТЭРГҮҮН ӨГҮҮЛЭЛ

БНМАУ-ЫГ ТУНХАГЛАСНЫ 60 ЖИЛ**С. Ишдорж**

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Одоогоос 60 жилийн өмнө 1924 оны 11-р сарын 26-нд Ардын эрхт Монгол улсын төрийн дээд эрхийг барих улсын анхдугаар их хурал тус орны анхдугаар үндсэн хуулийг баталж Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхагласан билээ. БНМАУ-ыг тунхагласан нь мөн оны 8-р сард хуралдсан МАХН-ын III их хурлаас Ардын хувьсгалын хэтийн төлөвийн асуудлаар, өөрөөр хэлбэл улс орныг капиталист биш хөгжлийн замаар замнуулах тухай тодорхойлон заасан намын жанжин шугамын дагуу авч гүйцэтгэсэн чухал арга хэмжээ болсон юм. Улс орон даяар ардын бүгд найрамдах байгууллыг тогтоон хэрэгжүүлэх тухай энэхүү шийдвэр нь засгийн бүх эрхийг хөдөлмөрчин ардын хурлууд, тэдгээрээс сонгогдож томилогддог байгууллагуудад олгосон хэрэг байв.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхагласан нь Аугаа их Октябрийн социалист хувьсгалын нөлөөгөөр Монгол Ардын Хувьсгалт Намын удирдлагаар 1921 онд ялсан Монгол Ардын хувьсгалын дараагаар монголын ард түмний амьдралд гарсан том түүхэн чухал үйл явдал байлаа.

Монголын ард түмэн Ардын хувьсгалын ялалтын үр дүнд улс орноосоо хятадын гамин цэрэг, цагаантны дээрэмчдийг хөөн зайлуулж, төрийн тусгаар тогтнолоо цоо шинэ үндсэн дээр байлдан олж, ардын хувьсгалт байгууллыг тогтоон, эх орноо нийгмийн дэвшил, шинэ амьдралын замаар хөгжүүлэх бололцоог олж авсан юм.

МАХН, Ардын засгийн газар, монголын ард түмэнд колонийн болон феодалын байгууллаас өвлөн үлдээсэн улс орны нэн их хоцрогдол, үндэсний аж үйлдвэр, санхүү-зээлийн системгүй, монголын зах зээлд гадаадын капитал ноёрхож, хүн ам бараг бүхэлдээ бичиг үсэг мэдэхгүй, шарын шашны нөлөөнд гүн автагдсан зэргээс урган гарсан тоо томшгүй бэрхшээлийг гэтлэн давах хэрэгтэй байлаа.

Ардын засгийн анхны жилүүдэд МАХН, Ардын засгийн газар улс орон даяар нийгэм-эдийн засаг, улс төрийн маш чухал ач холбогдол бүхий хувьсгалт арга хэмжээнүүдийг авч, хамжлагын ёсыг халж, феодалуудаас ард олонд ноогдуулж байсан албан татвар, гадаадын пүүсүүдэд төлөх өрийг хүчингүй болгожээ. Үүний зэрэгцээ ЗХУ-ын тусламжтайгаар улс орны эдийн засгийн улс, хоршооллын секторыг байгуулан, ардын гэгээрэл, эрүүлийг хамгаалах, шинжлэх ухаан, шинэ соёлыг хөгжүүлэх талаар эрэмбэ дараатай арга хэмжээ авч байв. Ялангуяа орон нутагт феодалын засаг захиргааг ардын хурлуудаар

сольж, орон нутгийн захирах байгууллагуудын тухай дүрмийг 1923 оны эхээр ардын засаг батлан гаргасны үр дүнд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад 1923—1924 онд явагдсан сонгуулиар сонгогдсон төлөөлөгчдийн 90 гаруй хувь нь малчин ардын төлөөлөгчид байв.

МАХН, Ардын засгийн газраас авч явуулсан эдгээр болон бусад хувьсгалт арга хэмжээ нь Ардын хувьсгалыг гүнзгийрүүлэн, хоцрогдсон орнууд капиталист хөгжлийн шатыг алгасан, ялсан пролетарийн орны тусламжтайгаар социализмд шилжин орж болох тухай В. И. Лениний сургаалыг¹ Монгол орны өвөрмөц нөхцөлд хэрэгжүүлэхэд хүргэжээ.

Ардын эрхт Монгол улсын анхдугаар их хурал ардын засгийн анхны гурван жилд Ардын засгийн газар болон бусад зарим яамдаас хийж гүйцэтгэсэн ажлын тухай тайланг сонсч хэлэлцээд, улс орныг капиталист биш хөгжлийн замаар хөгжүүлэх тухай МАХН-ын III их хурлаас баталсан түүхэн шийдвэрийг хэрэгжүүлэхийг төрийн байгууллагуудын үүрэг болгожээ. Анхдугаар их хурал үзэхдээ, «Ардын засгийн дотоод бодлого бол феодализмыг устгаж, улс орны олон жилийн хоцрогдлыг арилган, гадаадын худалдаа-мөнгө хүүлэгч капиталыг хязгаарлан шахаж гаргах, шинэ эдийн засаг, соёлыг бий болгон хөгжүүлэх хөдөлмөрчдийн аж амьдралыг дээшлүүлэх явдал мөн» гэжээ.

Анхдугаар их хурал улс орны гадаад бодлогыг тодорхойлохдоо, «Монгол улс нь дэлхийн бусад ард түмний урьд туулж өнгөрүүлсэн замыг давтах биш, харин орчин үеийн олон улсын байдлын дагуу жинхэнэ ардын байгууллын үзэл санаагаар хөгжих ёстой»³ гэсэн МАХН-ын III их хурлын заалтыг удирдлага болгон, «Ардын засгийн дотоод бодлогын үндсэн шинж агуулгад тохирсон монголын ард түмний... сэргэн мандахыг чин сэтгэлээсээ талархан, түүнд сэтгэл харамгүй дангаараа туслаж чадах хөдөлмөрчдийн ганц орон ЗСБНХУ-тай найрамдал, нягт хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд чиглэсэн гадаад бодлого л байвал зохино»⁴ гэж заажээ.

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 60 жилийн ойг бэлтгэн өнгөрүүлэх тухай МАХН-ын Төв хорооны 1984 оны нэгдүгээр сарын 31-ний өдөр гаргасан тогтоолд тэмдэглэхдээ МАХН-ын III их хурал, БНМАУ-ын анхдугаар их хурлын энэ түүхэн шийдвэр нь «манай орны улс төрийн болон нийгэм-эдийн засгийн амьдралд үндсэн өөрчлөлт хийх, БНМАУ-ыг цаашид социалист байгуулалтад шилжих зайлшгүй угтвар нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үе шат болсон юм»⁵ гэж дурдсан байна.

БНМАУ-ыг тунхагласнаас хойш өнгөрсөн 60 жилийн хугацаанд монголын ард түмэн МАХН-ын удирдлагын дор тэмцэл, ялалтын хэцүү бэрх боловч яруу алдарт замыг туулав. Манай ард түмэн эх орноо танигдашгүй болтол хөгжүүлэв.

БНМАУ капитализмыг алгасан социализмд шилжин орсон үйл явц нь ардчилсан ба социалист өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн хоёр шатыг дамжив. 1940 он хүртэл үргэлжилсэн ардчилсан шатанд ма-

¹ В. И. Ленин. ПСС, боть 41, 246-р тал.

² БНМАУ-ын анхдугаар их хуралдааны протокол. 48-р тал.

³ Монгол Ардын Намын III их хурал. УБ., 1966, 220-р тал.

⁴ БНМАУ-ын анхдугаар их хуралдааны протокол. 48-р тал.

⁵ «Үнэн», 1984.1.31

-най оронд ЗХУ-ын тусламжтайгаар үндэсний худалдаа-эд хэрэглэгчдийн хоршоо, улсын санхүү-зээлийн систем, улсын ба хоршооллын аж үйлдвэр, орчин үеийн тээвэр, холбоо байгуулагдаж, манай улс ардын аж ахуй, соёлын цоо шинэ салбарууд бий болов. Зөвхөн аж үйлдвэрийн хувьд тус хоёр орны хамтын ажиллагааны үр дүнд боловсруулах, уул уурай, эрчим хүч, барилгын материал, хэвлэл, хүнсний үйлдвэр зэрэг салбаруудтай болж, үндэсний шинэ залуу ажилчин анги бүрэлдэж бий болов. Манай ард түмэн өөрийн орноос гадаадын капиталыг шахан зайлуулж, феодалын хөрөнгийг хураан, шинээр төрж байсан капиталист элементийг таслан зогсоож устгав. МАХН ард иргэдийн чөлөөтэй шүтэх эрхийг тунхаглан зарлахын зэрэгцээ лам нарын ядуу доод, дунд хэсгийн хувьд маш уян хатан бодлого явуулж, тэдгээрийг нийгмийн тустай хөдөлмөрт татан оруулж, харин хувьсгалыг эсэргүүцсэн тэдний дээд хэсэгтэй эвлэршгүй тэмцэл хийсэн юм. МАХН, засгийн газар, монголын ард түмэн хувьсгалаар түлхэн унагаагдсан феодал ангийн үлдэгдлүүдээс хувьсгалын эсрэг удаа дараалан үйлдэж байсан адал балмад явдлыг таслан устгаж байлаа. Манай нам өөрийн эгнээнд гарсан баруун, «зүүний» хэлбэрлийг амжилттай гэтлэн давж, улс орноо капиталист биш хөгжлийн замаар хөгжүүлэх жанжин шугамыг гуйвалтгүй хамгаалжээ. Үүний зэрэгцээ МАХН, засгийн газар шинэ нийгэм байгуулах үйлсэд хөдөлмөрчдийг өргөнөөр оролцуулах талаар эрэмбэ дараатай арга хэмжээ авч байлаа.

Нам, засгаас улс орны батлан хамгаалах хүчийг зузаатгах, ЗХУ-тай тогтоосон найрамдал, холбоог зүйл бүрээр бэхжүүлэх талаар байнгын арга хэмжээ авч байсны ачаар монголын ард түмэн империалист түрэмгий дайнч хүчний нэг биш удаагийн өнгөлзлөгөөс хувьсгалт ололт, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг өмгөөлөн хамгаалж чадсан юм. Үүний тод жишээ бол 1939 онд Халх голын орчмоор манай оронд халдан довтолсон милитарист японы цэргийг монгол-зөвлөлтийн армийн хамтарсан хүч бут цохиж ялалт байгуулан, уг ялалтын 45 жилийн ойг энэ онд манай ард түмэн анд нөхдийнхөө хамт өргөн тэмдэглэсэн явдал мөн.

Ардчилсан шатны эцэс—1940 он гэхэд БНМАУ хөгжлийнхөө чухал үе буюу монголын ард түмэн улс орондоо социализмын үндсийг тавих үйлсэд шилжин оров. Гэвч манай орны социалист бүтээн байгуулалтын үйлсэд фашист түрэмгийлэгчдийн дэгдээсэн дэлхийн 2-р дайн илт саад тотгор болсон юм.

Дэлхийн 2-р дайны жилүүдэд БНМАУ холбоотныхоо интернационалч үүргийг биелүүлэн, гитлерийн фашизмыг бутцохиход нь зөвлөлтийн ард түмэн, түүний армид эд материалын тусламж, сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, дайны төгсгөлд манай зэвсэгт хүчин зөвлөлтийн армитай мөр зэрэгцэн японы милитаризмыг бутцохиход оролцсон билээ.

БНМАУ-ын капиталист биш хөгжлийн социалист шатанд манай орны эдийн засаг, соёл цаашид хөгжиж, ардчилсан шатанд үүсч бий болсон эдийн засгийн улс, хоршооллын сектор ЗХУ-ын техник-эдийн засгийн шийдвэрлэх тусламж, түүнчлэн социалист бусад орны дэмжлэгтэйгээр улам бэхжин өргөжиж, түүнийг төлөвлөгөөтэйгээр хөтлөн, социалист аж үйлдвэр гуйвалтгүй өсч, түүний шинэ салбарууд бий болж, барилга байгууламжийн ажил өргөн өрнөн, орчин үеийн тээвэр, холбоо хөгжсөн нь манай улсыг хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болгожээ. Энэ үед зөвхөн ЗХУ-ын техник-эдийн засгийн тусламжтайгаар манай оронд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, холбоо, ху-

далдаа, соёл үйлчилгээний 200 гаруй томоохон газрыг барьж ашиглалтанд оруулав.⁶ Тус орны хөдөө аж ахуйд зонхилж байсан ардын хэдэн зуун мянган тархай бутархай хувийн аж ахуйтныг 50-иад оны эцсээр хоршооллож дууссанаар БНМАУ-ын нийт улс ардын аж ахуйд социалист үйлдвэрлэлийн харилцаа ялж, капиталист биш хөгжлийн социалист шат дууссан байна. БНМАУ-д социализм бодит зүйл болж, «хүн бүр чадлаараа хийж, хүн бүрт хийснээр нь олгох» социализмын үндсэн зарчим хэрэгжих болов.

Улс орны эдийн засагт гарсан үндсэн өөрчлөлт нь хөдөлмөрчдийн соёлын түвшинг дээшлүүлэв. Насанд хүрэгсдийн бичиг үсэг үл мэдэх явдал аль хэдийнэ арилж, сургуулийн насны хүүхдүүдийг хөдөөд бүрэн бус дунд боловсролтой, хотод бүрэн дунд боловсролтой болгох зорилтыг амжилттай хэрэгжүүлж байна.

БНМАУ-ын улс төр, эдийн засаг, соёлын салбар дахь гүн гүнзгий өөрчлөлт нь монголын нийгмийн бүтэц, бүрэлдэхүүн их өөрчлөгдөхөд хүргэв. Одоо монголын нийгэм нь ажилчин анги, хоршооллосон ард гэсэн найрамдалт хоёр анги, түүнчлэн хөдөлмөрийн сэхээтний давхаргаас бүрэлдэж байна. Манай социалист төр нь хөдөлмөрчин ардын хувьсгалт ардчилсан диктатурт төрөөс ажилчин ангийн диктатурт төр болж хөгжлөө.

Эд бүхний үр дүнд улс орноо капитализмыг алгасан социализмын замаар хөгжүүлэх МАХН-ын жанжин шугам ялж, монголын ард түмний дээрх ололтыг 1960 онд баталсан БНМАУ-ын Үндсэн хуульд хуульчлан бататгажээ.

60-аад оны эхнээс манай улс хөгжлийнхөө шинэ үе болох социализмын материал-техникийн баазыг байгуулж дуусах үедээ шилжин оров. Энэ үеийн зорилтыг МАХН-ын IV программд тодорхойлон заахдаа, орчин үеийн шинжлэх ухаан-техникийн дэвшлийн үндсэн дээр социалист нийгмийн үйлдвэрлэх хүчнийг бүх талаар хөгжүүлэх, улс орны эдийн засгийн хүч чадлын түргэн өсөлтийг хангах, социалист соёлыг улам хөгжүүлэх, социалист нийгмийн харилцааг боловсронгуй болгох, шинэ хүнийг хүмүүжүүлэх ажлыг эрчимжүүлэх, эд бүхний үндсэн дээр ард түмний материаллаг аж байдал, соёлын түвшинг дээшлүүлэх явдал мөн⁷ гэжээ. Энэ үеийн эдийн засгийн гол зорилтыг МАХН тус оронд социализмын материал-техникийн баазыг байгуулж дуусгах, ойрын ирээдүйд БНМАУ-ыг аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгон хувиргах явдал мөн гэж үзсэн юм.

БНМАУ-д социализмын материал-техникийн баазыг байгуулж дуусгах зорилтыг дэвшүүлснээс хойш өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд манай орны нийгмийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3 гаруй дахин, үндэсний орлого 2,4 дахин, улс ардын аж ахуйн үндсэн фонд 6 дахин ажилчин, албан хаагчдын тоо 2,2 дахин өсөв.⁸

Манай хөдөө аж ахуй үндсээрээ өөрчлөгдөж, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр байнга хангагдан, нийгмийн аж ахуйн давуу талыг сайтар ашиглах, түүнд тэргүүн туршлага, шинжлэх ухаан-техникийн ололтыг нэвтрүүлэх замаар урагшлан хөгжиж байна. Тус орны малын тоо ардын засгийн жилүүдэд хоёр гаруй дахин өссөний зэрэгцээ одоо манай хөдөө аж ахуйд мал аж ахуйн ба үр тарианы 48 сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн 255 нэгдэл, тэжээлийн 14 аж ахуй

⁶ «Үнэн», 1984. X. 26

⁷ МАХН-ын XV их хурал. УБ., 1966 524-р тал.

⁸ «Коммунист», 1984., № 3. 96-р тал.

ажиллаж байна. Эдний мэдэлд тус орны нийт мал сүргийн 76 хувь гаруй нь хамрагдах болжээ. Хөдөө аж ахуйн нэг нэгдэлд дунджаар 72 мянган толгой мал, 15 морины хүчинд шилжүүлснээр 30 шахам трактор, 10 шахам автомашин, нэг сангийн аж ахуйд 28 мянган толгой мал, 10 мянга гаруй га тариалангийн талбай, 240 трактор ноогдох болжээ.⁹ Өөрөөр хэлбэл манай улсын хөдөө аж ахуй нь мал аж ахуй, газар тариалангийн салбараас бүрдсэн эдийн засгийн өндөр механикжсан салбар болсон байна. Сүүлийн 20 гаруй жилд манай хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 1,5 дахин өсөв. Нам, засгаас хөдөө аж ахуйн, ялангуяа мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах, ашиг шимийг нэмэгдүүлэх талаар олон чухал арга хэмжээ авсаар байна.

ЗХУ болон ах дүү социалист бусад орны тусламжтайгаар БНМАУ-д аж үйлдвэр, барилга байгууламжийн ажил эрчимтэй өрнөж, Дархан, Эрдэнэт, Багануур зэрэг аж үйлдвэрийн бүхэл бүтэн шинэ хотууд сүндэрлэн босов. Одоо манай улсын аж үйлдвэр, барилга, тээвэр, холбооны салбарынхан үндэсний орлогын 47,5 хувийг үйлдвэрлэх болсоны дээр зөвхөн аж үйлдвэрийн салбар нийгмийн нийт бүтээгдэхүүний 45 хувь, үндэсний орлогын 32 хувь, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийлбэр бүтээгдэхүүний 74 хувийг үйлдвэрлэж байна.¹⁰

Манай улс хүн ам тутамд ноогдох мах, ноос, улаан буудай, цахилгаан эрчим хүч, хатуу түлш үйлдвэрлэх, өнгөт металл болон ашигт малтмалын түүхийн эдийн зарим төрлийг олборлох, түүнчлэн 10 мянган хүн тутамд ноогдох суралцагчид, оюутан, эмч нар болон бусад мэргэжилтний тоо зэрэг эдийн засаг, соёлын олон чухал үзүүлэлтээр Азид төдийгүй дэлхийн бусад тивийн олон орноос түрүүлж байна.

Сүүлийн 20 гаруй жилд тус орны соёлын байгуулалтанд гүн гүнзгий өөрчлөлт гарч, үндэсний хэлбэртэй социалист агуулга бүхий урлаг, утга зохиол, улам цэцэглэн хөгжиж, дээд, тусгай дунд боловсролтой боловсон хүчин бэлтгэх, ардын эрүүлийг хамгаалах ажил эрчимтэй өрнөж, биеийн тамир, спортын ажлыг бүх нийтийн үйлс болгон хөгжүүлж байна. Одоо манай улсад ерөнхий боловсролын олон зуун сургуулиас гадна 7 их, дээд сургууль, 25 тусгай мэргэжлийн сургууль, 37 техник мэргэжлийн сургууль ажиллаж байна. Байгаль-техник нийгмийн ухааны арав гаруй хүрээлэн газар бүхий шинжлэх ухааны академи байгуулагдаж, эрдэм шинжилгээ-онол, практикийн тулгуур ба хавсарга судалгааг социалист байгуулалтын чухал зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн явуулж байна.

БНМАУ-ын эдийн засгийн хүч чадал өсөн нэмэгдэж, соёлын байгуулалтад олж байгаа амжилт нь монголын ард түмний материаллаг аж байдал, оюун санааны түвшинг дээшлүүлэн, манай орны нийт хүн амын дунд социалист ёсоор аж төрөх байдлыг хэвшүүлэн тогтоохын баталгаа болж байна.

МАХН, БНМАУ-ын засгийн газраас улс орондоо социализм байгуулж буй зөв мэргэн бодлого нь олон улсын тавцанд манай улс найрамдал, хамтын ажиллагаа, энх тайвны бодлого явуулахын уг сурвалж болж байна.

БНМАУ социалист хамтын нөхөрлөлийн салшгүй бүрэлдэхүүн хэсгийн хувьд нийгэм-эдийн засгийн нэг байгуулал, нэг үзэл суртал, нэгдмэл нэг зорилго бүхий ЗХУ болон социализмын ах дүү бусад оронтой тогтоосон хоёр ба олон талын хэлхээ холбоо, хамтын ажиллагаагаа

⁹ «Улаан-Од», 1984.VIII.10

¹⁰ «Үнэн», 1984.X.18.

өргөжүүлэн гүнзгийрүүлж байна. 1962 онд БНМАУ Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөлийн гишүүн болсноос хойш тус байгууллагын гишүүн орнуудтай эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-техникийн салбарт тогтоосон найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хэлбэрэлтгүй хөгжүүлж, социалист эдийн засгийн интеграцын Цогцолбор программ, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааны урт хугацааны зорилтот программыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож байна. ЭЗХТЗ-ийн гишүүн улсууд, юуны өмнө ЗХУ, манай оронд социализмын материал-техникийн бааз байгуулахад үлэмжийн их тусламж үзүүлж байна. 1961—1980 онд ЗХУ-ын техник-эдийн засгийн тусламжтайгаар манай улс ардын аж ахуй, соёлын хөгжилд шийдвэрлэх ач холбогдол бүхий аж үйлдвэр, хөдөө аж ахуй, барилга, соёл, ахуйн болон бусад салбарын 300 гаруй объект баригдаж ашиглалтад орсноос гадна энэ таван жилд аж үйлдвэр, хөдөө аж ахуйн болон орон сууц, соёл, ахуйн үйлчилгээний 340 гаруй газар баригдаж өргөтгөн шинэчлэгдэж байна.¹¹ Ах дүү социалист орнууд, нэн ялангуяа ЗХУ-ын тусламж нь БНМАУ-д социализмыг түргэн хурдацтай байгуулах, түүний хөгжлийн түвшинг социалист бусад орныхтой харьцангуй ахар богино хугацаанд ойртуулах, монголын ард түмний материаллаг аж байдлыг дээшлүүлэхэд чухал хүчин зүйл юм. БНМАУ-ын гадаад улс төрийн бодлогын чиг шугамыг МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэлд тодорхойлохдоо: «ЗХУКН, зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон найрамдал, тал бүрийн хамтын ажиллагааны харилцаагаа хойшид ч хэлбэрэлтгүй бэхжүүлэн гүнзгийрүүлэхэд бидний нэн тэргүүний зорилт оршино. Зөвлөлт Холбоот Улстай тогтоосон холбоо, найрамдал, ах дүүгийн барилдлагаа бол социализм байгуулах замаар бидний давшингуй хөгжихийн найдвартай баталгаа мөн»¹² гэжээ.

ЗХУКН, Зөвлөлт төрийг үндэслэн байгуулагч В. И. Ленин, Монголын хувьсгалын удирдагч Д. Сүхбаатар нарын үндэслэн байгуулсан монгол-зөвлөлтийн ард түмний ах дүүгийн уламжлалт найрамдал нягт хамтын ажиллагааг цаашид улам хөгжүүлэн бэхжүүлэхэд ЗХУКН-ын Төв Хороо, Зөвлөлт засгийн газрын урилгаар 1984 оны 10-р сард ЗХУ-д МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нөхөр Ж. Батмөнхийн хийсэн ажил төрлийн айлчлал чухал үйл явдал болов. Энэ айлчлалын ажиллах тухай мэдээнд «1981—1985 онд эдийн засаг, техникийн талаар хамтран ажиллах тухай монгол, зөвлөлтийн хэлэлцээр амжилттай хэрэгжиж байгаа нь БНМАУ-ын эдийн засгийн хөгжлийн хурдцыг түргэтгэх, хөдөлмөрчдийн аж байдлыг улам дээшлүүлэхэд тус дөхөм болж байна. Монгол, зөвлөлтийн хамтарсан уулын баяжуулах «Эрдэнэт» үйлдвэрийг богино хугацаанд барьж эзэмшин, БНМАУ-ын аж үйлдвэрийн төвийн районы түлш-эрчим хүчний цогцолборын хүч чадлын ихээхэн хэсгийг ашиглалтад оруулан, атрын сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуй байгуулж, орон сууцны цогцолбор болон нийгэм-аж ахуй, соёлын зориулалттай бусад барилга объектуудыг барьсан нь БНМАУ, ЗСБНХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа үр бүтээлтэйн яруу тод итгэл үнэмшилтэй жишээ мөн»¹³ гэж дурджээ.

Манай орны социалист бүтээн байгуулалтад ЗХУ-аас гадна Болгар, ардчилсан Герман, Чехословак, Унгар, Польш, Румын зэрэг со-

¹¹ «Үнэн», 1984.Х.26.

¹² МАХН-ын XVIII их хурал. УБ., 1981. 25-р тал.

¹³ «Үнэн», 1984.Х.30.

циализмын орнууд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, соёл, нийгэм-ахуйн үйлчилгээний газрыг барьж байгуулах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд ах дүүгийн тусламж үзүүлж байна.

Социалист хамтын нөхөрлөлийн орнуудын харилцаа, хамтын ажиллагаа, социалист эдийн засгийн интеграцын үйл явцыг гүнзгийрүүлэхэд ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын дээд хэмжээний 1984 оны 6-р сарын Москвагийн зөвлөлгөөний шийдвэр чухал ач холбогдол бүхий үйл явдал болж, ЭЗХТЗ-ийн чуулганы Гавана дахь 39-р хуралдаан гишүүн орнуудын 1986—1990 оны хамтын ажиллагааны чиглэлийг тогтоон, тэдгээрийн хооронд эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар 2000 он хүртэл хамтран ажиллах урт хугацааны программ боловсруулахын чухлыг заав. Ялангуяа ЭЗХТЗ-ийн чуулганы 39-р хуралдаанаар гишүүн орнуудын улс ардын аж ахуйн 1986—1990 оны төлөвлөгөөний зохицуулалтын явцыг авч хэлэлцээд, БНСВУ, БНКУ, БНМАУ-ын эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын социалист хөдөлмөрийн хуваарьд тэдгээрийн оролцоог өргөжүүлэхэд тус дөхөм үзүүлэх талаар ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын дээд хэмжээний зөвлөлгөөнөөс өгсөн заалтуудыг хэрэгжүүлэхэд онцгой анхааран, БНМАУ-д фосфоридын орд газруудыг эзэмшихэд хамтран ажиллахаар төлөвлөж байгаа нь ах дүү орнуудтай манай улсын үйлдвэрлэлийн хэлхээ холбоог улам өргөжүүлэн гүнзгийрүүлж, түүний эдийн засгийн өсөлтийг түргэтгэн нэмэгдүүлэхэд тус дөхөм үзүүлэн, ЭЗХТЗ-ийн гишүүн бусад орны эдийн засгийн хөгжлийн түвшинтэй БНМАУ-ын түвшинг аажмаар ойртуулан жигдрүүлэхэд чухал алхам болох ач холбогдол бүхий үйл явдал болов.

Ийнхүү социалист эдийн засгийн интеграцын хүрээнд манай улс ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой хоёр ба олон талын хамтын ажиллагаагаа цуцалтгүй өргөтгөн хөгжүүлж байгаа нь БНМАУ-д социализмын материал-техникийн баазыг амжилттай байгуулж дуусгахын шийдвэрлэх нэг чухал хүчин зүйл болж байна.

Монголын ард түмэн ЗХУ болон социализмын ах дүү бусад оронтой ойртон нягтарч байгаагаараа эх орныхоо социалист бүтээн байгуулалтыг түргэтгэж дэлхийн социализмын хүчийг бэхжүүлж байгаа юм.

БНМАУ ЗХУ болон социализмын ах дүү бусад улстай тогтоосон найрамдал, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэн, дэлхийн социализмын орнуудын эв нэгдлийг байнга бататган бэхжүүлэхийн хамт коммунист, ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжин, нийгмийн янз бүрийн байгуулал бүхий улсууд энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг тууштай хэрэгжүүлж империалист харгис дайнч түрэмгий хүчинд няцаалт өгөх, бат бэх энх тайван, улс түмний аюулгүй байдлыг хангах гадаад бодлого явуулж байна.

БНМАУ ба социализмын ах дүү орнуудын хоорондын улс төр, батлан хамгаалах, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын болон бусад харилцааны бүхий л систем нь социалист эв санааны нэгдлийн үзлээр тодорхойлогдож байна. Энэ үзэл санаа манай оронд БНСВУ, БНУАУ-ын дээд хэмжээний төлөөлөгчид зочилж, саяхан манай нам-засгийн төлөөлөгчид Бүгд Найрамдах Куба Улсад айлчлах үеэр хамтран гаргасан баримт бичгүүдэд тод тусгалаа олсон билээ.

Манай улс социализмын ах дүү орнууд болон хувьсгалт бусад хүчний хамт биеэ даасан үндэсний улсуудын ард түмнээс өөрсдийн орны улс төрийн тусгаар тогтнол, эдийн засгийн бие даасан байдлаа бэхжүүлэхийн төлөө, нийгмийн дэвшлийн төлөө, шинэ колоничлолын өнгөлзлэгийг таслан зогсоох, олон улсын эдийн засгийн харилцааны

шударга журам тогтоохын төлөө явуулж буй тэмцлийг идэвхтэй дэмжиж байна.

Ялангуяа БНМАУ социалист чиг барижааны Афганистан, ардчилсан Иемен, Ангол, Кампучи, Этиоп болон бусад оронтой найрамдал, эв санааны нэгдлийн харилцааг хөгжүүлж, хувьсгалт Никарагуа улс, Сальвадорын эх орончидтой эв санааны нэгдэлтэй байдаг юм. Монголын ард түмэн империалист харгис хүчний даралт шахалт, арьсны үзэлт дэглэм, сионизмын түрэмгийлэлд өртөгдөж буй улс түмэн, юуны өмнө Палестин, Ливаны эх орончидтой эв санааны нэгдлээ илэрхийлэн, тэдний шударга тэмцэлд бололцооныхоо хирээр дэмжлэг үзүүлж байна.

Нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших Ленинч зарчмыг хэрэгжүүлэх нь манай ардын төрийн гадаад бодлогын тулгуур зарчмуудын нэг юм. БНМАУ нийгэм-эдийн засгийн өөр байгуулал бүхий улсуудтай төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрхийн үндсэн дээр харилцан ашигтай харилцааг тогтоон хөгжүүлж байна.

Одоо манай улс дэлхийн 94 оронтой дипломат харилцаа барин, 30 гаруй улстай худалдаа-эдийн засгийн, 40 гаруй оронтой соёлын харилцаатай ажиллаж байна. БНМАУ 1961 оны 10-р сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнээр элсч, одоо олон улсын 80 гаруй байгууллагын ажилд идэвхтэй оролцон, улс түмний энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны үйл хэргийг тууштай өмгөөлөн хамгаалж байна. Үүнийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXIX чуулган манай улсын оруулсан «Улс түмэн энх тайван орших эрхийн»¹⁴ тухай Тунхаглалыг баталсан явдал гэрчилж байна. Дэлхийн хамтын нийгэмлэгийн эл Тунхаглалд манай гаригийн улс түмэн энх тайван орших эрхэм ариун эрхтэйг ёслол төгөлдөр тунхаглан баталж, энэ эрхийг хамгаалж хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх явдал улс гүрэн бүрийн үүрэг мөн гэж заажээ. Дэлхий дахиныг халуун цөмийн хөнөөлт дайн нөмрөх аюул улам ихэсч байгаа өнөө үед энэхүү Тунхаглал нь бат бэх энх тайван, олон улсын аюулгүй байдлыг бататгах талаар улс түмний тавьж буй хүч чармайлтад тус дөхөм үзүүлэх улс төрийн ихээхэн ач холбогдолтой маш энэрэнгүй үзэл санаа бүхий баримт бичиг мөн.

АНУ ба НАТО-гийн орнууд, империалист японы болон бусад орны харгис эрх баригчдаас явуулж буй түрэмгий дайнч бодлого, ялангуяа АНУ-ын засаг захиргаа өрнөд Европт дунд тусгалын далавчит, «Першинг—2» пуужингуудыг байрлуулж, Алс Дорнод болон Номхон далайн районд «Томагавк» зэрэг пуужинг зөөж авчиран, сансрын уудмыг хөнөөлт зэвсгээр зэвсэглэж, цэрэг зэвсгийн зардлаа урьд өмнө үзэгдээгүйгээр нэмэгдүүлж байгаагийн уршгаар халуун цөмийн сүйрэлт дайн гарах аюул улам ихэсж байна. «Ийм нөхцөлд энх тайвны төлөө, дайны эсрэг тэмцэхээс илүү чухал зорилт байхгүй билээ»¹⁵ гэж МАХН-ын Төв Хорооны ээлжит бус VIII бүгд хурал тэмдэглэсэн юм.

Монголын ард түмэн АНУ-ын засаг захиргаанаас өөрийн хөлсний этгээдүүдийг туурхиран хувьсгалт Никарагуа улсын эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдэж байгааг нийт дэвшилт хүн төрөлхтний нэгэн адил эрс шийдвэртэй эсэргүүцэн буруушааж байна.

БНМАУ Азийн социалист орны хувьд бүх хүн төрөлхтний тэн хагасаас илүү нь оршин суудаг өргөн уудам энэ тив дэх энх тайван

¹⁴ «Үнэн», 1984.XI.15.

¹⁵ «Үнэн», 1984.VIII.24.

байдлыг сахин хамгаалах талаар их анхаарал тавьж байдаг юм. Энэ ариун эрхэм нандин зорилгод чиглэсэн «Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц боловсруулж гарын үсэг зурах»¹⁶ талаар МАХН-ын XVIII их хурлаас дэвшүүлсэн манай улсын санал ч дэлхийн энхийг эрхэмлэгч улсууд, олон улсын өргөн олон нийтийн дэмжлэгийг олсоор байна.

Өнөө үеийн олон улсын байдал ээдрээтэй, хурцадмал байгаа үед БНМАУ өөрийн өмнөд хөрш БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгохын төлөө байгаа бөгөөд ингэх нь Азийн бүс нутгийн байдлыг сайжруулахад тус дөхөм үзүүлэх ач холбогдолтой юм. Энэ үүднээс манай улс зөвлөлт, хятадын улс төрийн зөвлөлдөх уулзалтыг үр ашигтай алхам гэж үзэж байна. Харин зөвлөлт, хятадын харилцааг сайжруулахад гуравдахь орнууд, тухайлбал БНМАУ-ын ашиг сонирхлыг хөндсөн Хятадын тавьж байгаа шаардлага, өөрөөр хэлбэл манай засгийн газрын хүсэлтээр БНМАУ-ын нутагт түр байрлаж буй зөвлөлтийн цэргийн ангиудыг БНМАУ-аас гаргах тухай асуудлын хувьд гэвэл, энэ нь зөвлөлт-хятадын хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалтын ярилцах асуудал огт биш юм. Энэ асуудал зөвлөлт, хятадын харилцааг хэвийн болгоход ямар нэг саад тогтор ч болох ёсгүй. Энэ асуудалтай холбогдуулан ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчдийн дарга нөхөр К. У. Черненко-гоос «Бид гуравдахь орны ашиг сонирхлыг хохироох замаар хэлэлцэн тохирохыг зөвшөөрч чадахгүй»¹⁷ гэж хэлснийг монголын олон нийт ЗХУКН, Зөвлөлт засгийн газрын баримталж буй тууштай зарчимч байр суурь хэмээн үнэлэн үздэг юм.

БНМАУ-ын гадаад бодлого нь манай оронд социализмыг байгуулж дуусгахын энх тайван нөхцөлийг хангах, Ази болон дэлхий дахины улс түмний аюулгүй байдлыг сахин бэхжүүлэхэд чиглэж байна.

Ардын эрхт Бүгд Найрамдах улсыг тунхагласнаас хойш монголын ард түмний туулж өнгөрүүлсэн 60 жилийн түүхэн замналыг эргэн харахад манай ард түмэн өөрийн шаргуу хөдөлмөрөөр МАХН-ын шалгарсан удирдлагын дор ЗХУ болон социализмын ах дүү бусад орны тусламж дэмжлэгт түшиглэсний ачаар улс орноо капитализмыг алгасан социализмд дэвшүүлэн оруулж, БНМАУ-ыг дэлхийн социализмын салшгүй бүрэлдэхүүн хэсэг, дэлхийн хамтын нийгэмлэгийн нэр хүндтэй гишүүн орон болголоо.

Монголын ард түмэн олсон үлэмжийн их ололтоо улам бататган, эх орондоо социализмыг байгуулж дуусгах зорилтыг амжилттай хэрэгжүүлэх шийдвэр төгс байна.

¹⁶ Монгол Ардын Хувьсгалт Намын XVIII их хурал. УБ., 1981, 38-р тал.

¹⁷ «Правда», 3.III.1984.

60 ЛЕТ ПРОВОЗГЛАШЕНИЯ МНР

(Р е з ю м е)

Провозглашение Монголии Народной Республикой 26 ноября 1924 года в соответствии с решением III съезда МНРП, как отмечает автор статьи, явилось важнейшим историческим событием в жизни монгольского народа, произошедшим после победы Монгольской Народной революции 1921 года. Этим была передана вся полнота государственной власти в стране хуралам трудящихся аратов революционной Монголии и избираемым ими органам как в центре, так и на местах.

В статье подробно излагается тренистый, но славный путь, пройденный монгольским народом за 60 лет со времени провозглашения МНР. Главным итогом развития МНР является переход Монголии к социализму, минуя капитализм. Этот переход, по мнению автора статьи, совершился двумя этапами: демократическим и социалистическим. На демократическом этапе, продолжавшемся примерно до 1940 года, с помощью Советского Союза в МНР были созданы национальная торгово-потребительская кооперация, государственная финансово-кредитная система, государственная и кооперативная промышленность, современный транспорт и связь. Был вытеснен из страны иностранный капитал, экспроприрована собственность феодалов, ликвидированы нарождавшиеся капиталистические элементы. В стране получила развитие народное образование и здравоохранение. Формировалась и развивалась национальная по форме, революционная по содержанию культура.

МНРП успешно преодолела возникший в своих рядах правый и «левый» уклон. Монгольским народом решительно пресекались неоднократные авантюрные действия свергнутого народной властью класса феодалов. Партией и правительством МНР принимались последовательные меры по широкому вовлечению трудящихся в дело строительства нового общества. Опираясь на помощь и поддержку Советского Союза, монгольский народ сумел защитить свои революционные завоевания, отстаивать свою государственную независимость от посягательств агрессивных империалистических и милитаристских сил.

На социалистическом этапе, продолжавшемся примерно до 1960 года, хотя в его начальный период делу строительства основ социализма в МНР помешала развязанная фашистскими агрессорами вторая мировая война, при решающей технико-экономической помощи СССР, а также при поддержке других социалистических стран расширялись и укреплялись сформированный в МНР на демократическом этапе социалистический уклад-государственный и кооперативный секторы экономики путем ведения их на плановой основе, неуклонно возросла социалистическая промышленность, создавались её новые отрасли, развертывалась широкая строительная работа и дальнейшее развитие получили современные средства транспорта и связи, что привело к превращению МНР из страны аграрной в аграрно-индустриальную. С завершением в конце 50-х годов кооперирования сотен тысяч единоличных аратских хозяйств социалистические производственные отношения победили во всем народном хозяйстве МНР и тем

самым в основном завершился социалистический этап некапиталистического пути развития страны.

Примерно с начала 60-х гг. МНР вступила в новый период своего развития—период завершения создания материально-технической базы социализма. Центральной экономической задачей этого периода, как определила IV программа МНРП, является превращение МНР из страны аграрно-индустриальной в индустриально-аграрную.

Далее автор статьи на основе фактических материалов пишет об огромных успехах монгольского народа, которых он достиг в социалистическом строительстве за последние 20 с лишним лет своим самоотверженным трудом под испытанным руководством МНРП при помощи Советского Союза и других братских стран социализма. В статье автор также подробно освещает внешнеполитическую деятельность МНРП и правительства МНР и их инициативы в тесной связи с современной международной обстановкой и вытекающими из неё задачами.